



“ ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТ ” ТӨСЛИЙН ТОЙМ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД:

Пипл ин Нийд (ПИН) ОУТББ,
Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС),
Хөгжлийн Шийдэл ТББ,
Каритас Чех Републик (КЧР) ОУТББ

ХУГАЦАА:

2022 оны 1-р сараас 2025 оны 12 сар

БАЙРШИЛ:

Улаанбаатар хот, Эрдэнэт хот, Сэлэнгэ аймаг

ЮУ:

Европын холбооны Свич-Эйшиа хөтөлбөрийн 2.2 сая ам.долларын санхүүжилтээр “Эдийн засгийн ногоон шилжилт” (ЭЗНШ) нэртэй дөрвөн жилийн төсөл хэрэгжиж байна. Монгол улс хүлэмжийн хийн ялгарлаа бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой уг төсөл нь Монголын хүнс, ус ундааны салбар дахь бичил жижиг дунд бизнес эрхлэгчид болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийг тойрог эдийн засгийн талаар сургалт мэдээллээр ханган, зах зээлд суурилсан эко тэмдэг, ногоон баталгаажуулалтыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ЯАГААД:

Монгол улсын хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувиар бууруулах үндэсний стратегитэй нийцүүлэн хүнс, ус ундаа үйлдвэрлэлийн салбарт Европын Холбооны Свич Эйшиа хөтөлбөрөөс анх удаа хэрэгжүүлж буй төсөл юм. Тус салбар нь хүлэмжийн хий ялгаруулагч томоохон салбаруудын нэг ба ЭЗНШ төслөөр дамжуулан Европын холбооны “Тариаланчаас таны ширээнд” зарчмын сайн туршлагаас уг салбарт нэвтрүүлж, нүүрстөрөгчийн ялгарал багатай, нөөцийг үр ашигтай зарцуулдаг тойрог эдийн засагт шилжихэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

ЯАЖ:

Төслийн хүрээнд эко тэмдэг, ногоон гэрчилгээ олгох тусгай алба байгуулж, БЖДҮ болон жижиглэн худалдаа эрхлэгчдийн дунд байгальд ээлтэй, ухаалаг, нөөцийг хэмнэх сайн туршлагыг сурталчлах цахим платформ ашиглан хэрэглэгч болон ногоон үйлдвэрлэгчийн хооронд гүүр болж ажиллах юм. Мөн оролцогч талуудыг хамруулсан эко тэмдгийн ач холбогдлын хүрээнд олон нийтийн зан үйлд нөлөөлөх компанит ажлыг явуулан өргөн хүрээнд мэдлэг, мэдээлэл түгээх болно.

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Үр дүн 1:

Хөдөө аж ахуй, хүнс, ус, ундааны салбарын хууль эрх зүй, бодлогын орчныг сайжруулахад нөлөөлж ногоон баталгаажуулалт, эко тэмдгийн стандарт нутагших суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

Үр дүн 2:

Хөдөө аж ахуй, хүнс, ундааны салбарын БЖДҮ эрхлэгчид, борлуулагчид өртгийн ногоон сүлжээ бүхий тойрог эдийн засгийн мэдлэг, чадвар, туршлагатай болсноор өөрийн бараа үйлчилгээг баталгаажуулах, эко тэмдэг авах боломжтой болно.

Үр дүн 2-ын зорилтот бүлэг:

Хүнс, ус, ундааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1500 БЖДҮ эрхлэгчид, 30 бизнесийн холбоод (Ганцаарчилсан зөвлөх үйлчилгээ- 20 БЖДҮ, Ногоон Санхүүгийн техникийн туслалцаа: 10 БЖДҮ эрхлэгч) 300 жижиглэн худалдаа эрхлэгчдийг тойрог эдийн засагт шилжихэд нь томоохон нөлөө үзүүлнэ.

Үр дүн 3:

БЖДҮ эрхлэгчид болон борлуулагч нар ногоон баталгаажуулалт, эко тэмдэг авахад туслах цахим платформ хөгжүүлж, баталгаажуулах үйлчилгээг үзүүлнэ.

Үр дүн 4:

Ногоон баталгаажуулалт, эко тэмдгийг одоогийн цахим төлбөрийн болон урамшууллын системүүдтэй холбоно.

Үр дүн 5:

Зан дадлын өөрчлөлтийг нэвтрүүлэх зорилготой ногоон баталгаажуулалт, эко тэмдгийг сурталчлах аян явуулна.

ТӨСЛИЙН 2024 ОН ХҮРТЭЛХ ҮР ДҮН, ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ТОЙМ:

Зах зээлд суурилсан ногоон гэрчилгээ, эко тэмдгийн шилдэг туршлагаудаас судалж хоёр шинэ стандартыг (Хүнсний тогтвортой үйлдвэрлэл болон эко бүтээгдэхүүн, тэр дундаа савласан цэвэр усанд тавигдах шаардлага, стандарт) боловсруулж байна




Монголын хөдөө аж ахуй, хүнс, ундааны жижиг дунд бизнес эрхлэгчид, жижиглэн худалдаачид болон бизнес эрхлэгчдэд зориулсан тойрог эдийн засгийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалтын, сургалт зохион байгуулагчийн, менторингийн болон суралцагчийн гэсэн 4 төрлийн техник, арга зүйн гарын авлага боловсруулагдсан.

Сэлэнгэ, Эрдэнэт хотод ЭЗНШ төслийн сургалтын салбарууд нээгдэв.




БЖДҮ болон жижиглэн худалдаа эрхлэгчдэд зориулсан тойрог эдийн засаг, тогтвортой үйлдвэрлэл, нөөцийн зөв менежментийн 47 сургагч багш сургаж бэлтгэгдсэн.

Хүнсний салбарын 90 БЖДҮ, жижиглэн худалдаа эрхлэгчдийн төлөөллийг “Хурдасгуур хөтөлбөр”-ийн сургалтад хамруулав.




БЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг илүү байгальд ээлтэй болгох, нөөцөд ээлтэй, эрчим хүч болон санхүүгийн хэмнэлттэй явуулах тал дээр зөвлөгөө өгөх 25 ментор чиглүүлэгч бэлтгэгдлээ.

Нийгмийн зан дадлыг өөрчлөх хэрэгцээ, боломж, урамшууллын судалгааг Улаанбаатар, Сэлэнгэ, Эрдэнэтийн 700 гаран БЖДҮ болон жижиглэн худалдаа эрхлэгчид, хэрэглэгчдийн дунд зохион байгуулж дүгнэлт тайланг бэлтгэж гаргалаа.



Хүнсний салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох аргачлалыг боловсруулж 20 БЖДҮ-ийн эхний жишиг ААН-ийн ХХЯ-ыг тооцоолж байна.

Хөдөө аж ахуйн хүнс, ундааны салбарын үндэсний бодлого, тогтолцоо, одоо байгаа эко тэмдэг/баталгаажуулалтын стандартын талаарх судалгаа хийгдсэн.



Олон улсад хэрэгжиж буй эко тэмдэг/ногоон баталгаажуулалтын сайн туршлага, схем, тэдгээрийг Монгол улсад нутагшуулах судалгааг боловсруулж дүгнэв.

Хөдөө аж ахуй, хүнс, ус ундааны салбарын үнэлгээ хийгдлээ.



Ногоон баталгаажуулалт, эко тэмдэг авахад туслах цахим платформ хөгжүүлэлтийн судалгаа бэлэн болсон.